


ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны ХЭГ/3626, Хяналт хэрэгжүүлэх газрын 2026 оны 02/152 дугаартай албан бичгээр ирүүлсэн Нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар хорооны оршин суугч Н.Нямхүүгийн өргөдлийн дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2026 оны 04/07 дугаартай удирдамжийн хүрээнд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, “Нэгдсэн төслийн удирдлагын газар”-ын Нүхэн гарцын төсөл, зөвлөх “Гео зураглал” ХХК, ерөнхий гүйцэтгэгч “Чайна тисижу сивил инженеринг групп” ХХК, туслан гүйцэтгэгч “Нью синдкат” ХХК болон “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн замын 2 дугаар ангийн төлөөллийг байлцуулан төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2026 оны 02 дугаар сарын 03-16-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.



Эрчим хүчний гудамжны тойргийн замын орчмын нөхцөл байдал



Баянгол дүүргийн 20-р хороо, явган хүний гарц, гэрлэн дохионы орчмын нөхцөл байдал



Төмөр замын төмөрбетон хашаа, “Энхжин” худалдааны төвийн явган гарц



Төмөр зам, авто зам дээгүүр баригдаж буй явган хүний 2 түвшний гарц

Монгол Улсын Сангийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон “Чайна тисижу сивил инженеринг групп” ХХК, “Чайна рэлвэй интэрнешнл групп” ХХК, БНХАУ-ын “Машин механизм аж үйлдвэрийн корпораци” консорциум хооронд БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гарц шинээр барих төслийн ажлын зураг төсөл боловсруулах болон барилга угсралтын ажлыг түлхүүр гардуулах нөхцөлөөр гэрээг 2022 онд байгуулан эхэлсэн бөгөөд техник, технологийн хяналт тавих, зөвлөх үйлчилгээг 2024 оноос “Гео зураглал” ХХК гүйцэтгэж байна.

Зургийн байгууллагын 2023 онд боловсруулсан зураг төсөлд төмөр зам доогуур гарах 18 у/м явган зорчигчийн нүхэн гарц барихаар төлөвлөсөн боловч зөвхөн төмөр зам доогуур гарах 18 у/м явган зорчигчийн нүхэн гарц барихаар төлөвлөсөн байсан нь бусад авто замтай уялдахад хүндрэлтэй, зорчигчдын аюулгүй зорчих нөхцөлд үзүүлэх сөрөг нөлөөг багасгахгүй байсан тул төмөр, авто зам дээгүүр явган хүний гүүрэн гарц хийхээр захиалагчийн зүгээс шийдвэрлэсэн байна.

Нийслэлийн төслийн удирдлагын газрын даргын баталсан 2025 оны НТУГ-ЗАД-25/03 ажлын даалгаврын дагуу “Таван шарын төмөр замын гармын баруун тал, Найрамдлын зам, төмөр зам дээгүүр урагш нэвтрэх явган хүний 2 түвшний гарц”-ын “Өсөн үржих констракшн” ХХК боловсруулсан зураг төслийн дагуу “Нью синдкат” ХХК 2025.11.15-нд эхлүүлж, 2026.05.15-нд дуусгах төлөвлөгөөтэй гүйцэтгэж байна.

Нийслэлийн зам тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч болон “Хөгжлийн хөтөч дэд бүтэц” төслийн зохицуулагч нарын 2021.08.17-ны өдрийн баталсан авто машины нүхэн гарцын ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг үндэслэн “Ирээдүйн ган зам” ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан 24/27 дугаартай гэрээний дагуу Таван шарын төмөр замын гармын баруун талын нүхэн гарцын нэмэлт ажлын өөрчлөлтийн ГУК-25/25

шифртэй зураг төслийг “Гео урбан консалтинг” ХХК боловсруулж, төмөр замын урд талын авто зам, явган зам, дугуйн замын гүйцэтгэгч хийж байна.

“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн 2024.11.27-ны 06/4572, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Замын хөгжлийн газрын 2024.11.25-ны 03/2809, “Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ-ын 2024.11.22-ны 01/621 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан тус 396 дугаар километрийн 9 дүгээр зуутад байрлах төмөр замын гармыг хаах тухай Зам, тээврийн сайдын 2024.11.29-ний А/254 дугаар тушаал гарсан бөгөөд гармын тээврийн хэрэгсэл зорчих хэсгийг 2024.12.15-ны өдрөөс, явган хүний гарцыг түр үлдээн 2025.06.15-ны өдрөөс эхлэн хаахаар шийдвэрлэсэн байна.

“Улаанбаатар төмөр зам” ХНН нь гармыг татан буулгах тухай зарлал, мэдээллийг олон нийтэд урьдчилан өгч 2024.12.15-ны өдөр гармын байгууламж, тэмдэг тэмдэглэгээг буулгаж, зурвас газрын заагт хашаа барьж хаасан. Харин явган хүний гарцыг нөхцөл байдлыг харгалзан 2025.08.08-ны өдөр хаасан бөгөөд түүнээс хойш явган зорчигчид 396 дугаар километрийн 2 дугаар зуутад /Энхжин захын хойд талд/ байрлах нүхэн гарцаар нэвтэрч байна.

Тус хяналт шалгалтаар авто замын зарим хэсэгт явган замын хашлага, хавтан хийгдээгүй, хөвөөний өргөн хангалтгүй, явган зам, дугуйн зам, хажуу налууугийн хэлбэржүүлэлт зураг төслийн дагуу бүрэн гүйцэтгээгүй, гэрлэн дохионы явган замын хаалт, хашлага, тойргийн орчим хаалт хашлага дутуу хийгдсэн, хүнд даацын тээврийн хэрэгслүүд зогсоолоор ашиглаж хог хаягдлаар дүүрсэн, тухайн орчинд дуу чимээ, тоосжилт их байгаа, нүхэн гарцын зорчих хэсгийн асфальтбетон хучилтад нүх гарсан, торон хагарал үүссэн, нүхэн гарцын хийцийг уснаас хамгаалах арга хэмжээ хангалтгүйгээс төмөрбетон хийцийн залгаасаар ус нэвчиж, цаашид бетон хийцийн бат бэхэд сөргөөр нөлөөлөхөөр байгаа зөрчил дутагдлууд илэрсэн.

“Энхжин” худалдааны төвийн орчмын тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн замын зааг тодорхой бус байгаагаас явган зорчигчийн зам дээр тээврийн хэрэгсэл зорчдог, мөн гэрэлтүүлэг хангалтгүй, төмөр замын нүхэн гарцын шат болон тэргэнцэр зорчих хэсгийн налуу огцом зэрэг эрсдэлтэй нөхцөл байдлыг бууруулах, норм дүрэм, стандартад нийцүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх талаар эзэмшигч тал болох “Улаанбаатар төмөр зам” ХНН-т 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 10/824 дугаартай албан бичгийг, мөн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид анхаарах асуудлын хүрээнд захиалагч тал болох “Нэгдсэн төслийн удирдлагын газар”-ын Нүхэн гарцын төсөлд улсын ахлах байцаагчийн 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 04-00-02/007/01 дугаартай албан шаардлага, 04-00-02/007/03, 04-00-02/007/04 дугаартай зөвлөмжийг 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 10/817 дугаартай албан бичгийн хамт тус тус хүргүүлсэн.

Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд өргөдөл гаргасан иргэн Н.Нямхүүд авсан арга хэмжээний талаарх мэдээллийг иргэн Н.Нямхүүд утсаар болон 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 10/823 дугаартай албан бичгээр хариуг өгсөн.

Мөн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 10/957 дугаартай албан бичгээр хийсэн хяналт шалгалт, авч хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг хүргүүлсэн. Шалгалтын мөрөөр захиалагч “Нэгдсэн төслийн удирдлагын газар”-ын Нүхэн гарцын төслийн зүгээс төслийн ажлын явц, иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах талаар уулзалтыг хийж, тухайн хорооны оршин суугчдад мэдээлэл өгч, аюулгүй байдлыг хангуулахад холбогдох ажлыг зохион байгуулж байна.

